



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРААС
2018 ОНД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ
БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр
Улаанбаатар хот

АГУУЛГА

АГУУЛГА.....	1
НЭГДСЭН ТАЙЛАН.....	2
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
ИЛЭРСЭН АСУУДЛУУД	5
НЭГДСЭН ДҮГНЭЛТ	10
ЗӨВЛӨМЖ	10

_____ оОо _____

НЭГДСЭН ТАЙЛАН

2018.12.17

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2018 оны А/14 дүгээр тушаалаар баталсан дотоод аудитын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 23-ны өдрийг дуустал, ажлын 7 өдрийн хугацаанд аудит хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 5.3, 5.4 дэх заалт, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2018 оны А/14 дүгээр тушаалаар баталсан дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөө болон холбогдох бусад хууль тогтоомж.

Дотоод аудитын зорилго:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд аудит хийж, гэрээний үүргийн хэрэгжилтийн талаар дүгнэлт, зөвлөмж гаргахад оршино.

Аудитын цар хүрээ:

Аудитад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний үүрэг, хариуцлага, эрх зүйн үндэслэл, хэрэгжилт, холбогдох нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа, тендерийн урилга хэвлэх өдөр тутмын сонинг шалгаруулах тендерийн баримт бичиг зэргийг хамруулж дотоод аудит хийлээ.

Дотоод аудитын хамрах хугацаа:

2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэл.

Илэрсэн асуудлууд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан нийт 7 гэрээнд гэрээний үүрэг хариуцлага, үндэслэл, хэрэгжилт (I), нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа (II),

худалдан авах ажиллагаа (III) гэсэн 3 шалгуур үзүүлэлтээр аудит хийхэд дараах үр дүнтэй байна.

Шалгуур 1. Гэрээний үүрэг хариуцлага, үндэслэл, хэрэгжилт

Гэрээнд хууль, эрх зүйн үндэслэлийг сайн тусгасан боловч гэрээний зарим заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Шалгуур 2. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа

Хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн шалгахад зарим ажил гүйлгээ нь анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй байна.

Шалгуур 3. Худалдан авах ажиллагаа

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хэвлэл, мэдээллийн байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажилласан байна.

Нэгдсэн дүгнэлт:

Хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилт, явц, баримтын бүрдэл зэргийг харгалзан үзэж **“Сайжруулалт хэрэгтэй”** гэсэн дүгнэлтийг гаргаж байна.

Зөвлөмж:

Нийт 5 зөвлөмж өгч ажиллалаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (цаашид “ТӨБЗГ” гэх)-аас 2018 онд нийт 111 гэрээ байгуулснаас хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан 7 гэрээг авч аудит хийсэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар түүнийг төлөөлөн Захиргаа, хууль зүйн хэлтэс (цаашид “ЗХЗХ” гэх)-ийн хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн Б.Дэлгэрцэцэг гэрээ байгуулж, гэрээний бүртгэлийг ЗХЗХ-ийн хуулийн мэргэжилтэн Б.Амарзаяа хөтөлж, санхүүгийн ажил гүйлгээг ЗХЗХ-ийн ахлах нягтлан бодогч Ж. Мөнхтүвшин гүйцэтгэжээ. Харин 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн урилгыг нийтлүүлэх үндэсний хэмжээний өдөр тутмын сонинг шалгаруулах зөвлөхийн бус үйлчилгээний тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар Худалдан авах ажиллагааны хэлтэс (цаашид “ХААХ”)-ийн мэргэжилтэн С.Чинбат ажилласан байна.

Нийт 7 гэрээг төрлөөр нь авч үзвэл “Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал”-ыг нийтлэх, хамтран ажиллах 4 гэрээ, ажил гүйцэтгэх 3 гэрээ байна. Гэрээний талаархи дэлгэрэнгүй мэдээллийг 1 дүгээр хүснэгтээр харуулав.

1 дүгээр хүснэгт

Д / д	Гэрээний нэр	Гэрээний дугаар	Гэрээний үүрэг	Гэрээний үнийн дүн	Байгуулсан огноо	Дуусах хугацаа	Гэрээг байгуулсан албан тушаалтан	Гэрээний тал
1	"Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал"-ыг нийтлэх, хамтран ажиллах гэрээ	03/03	Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зар, мэдээ мэдээллийг хэвлэн нийтлэх	1/8 нэг бүрийн үнэ 70,000	2018.02.01	2018.12.31	ТӨБЗГ-ын дарга Ц.Ням-Осор	Өдрийн сонин
2	"Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал"-ыг нийтлэх, хамтран ажиллах гэрээ	03/04	Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зар, мэдээ мэдээллийг хэвлэн нийтлэх	1/8 нэг бүрийн үнэ 50,000	2018.02.01	2018.12.31	ТӨБЗГ-ын дарга Ц.Ням-Осор	"Монгол Ньюс" ХХК (Өнөөдөр сонин)
3	"Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал"-ыг нийтлэх, хамтран ажиллах гэрээ	03/05	Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зар, мэдээ мэдээллийг хэвлэн нийтлэх	1/8 нэг бүрийн үнэ 80,000	2018.02.01	2018.12.31	ТӨБЗГ-ын дарга Ц.Ням-Осор	"Монгол Ньюс" ХХК (UB Post сонин)
4	"Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал"-ыг нийтлэх, хамтран ажиллах гэрээ	03/06	Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зар, мэдээ мэдээллийг хэвлэн нийтлэх	нэг бүрийн үнэ 50,000	2018.02.01	2018.12.31	ТӨБЗГ-ын дарга Ц.Ням-Осор	"Засгийн мэдээ" ХХК (Зууны мэдээ сонин)
5	Ажил гүйцэтгэх гэрээ	05/09	ТӨБЗГ-ын үйл ажиллагааны урсдаг титр мэдээг олон нийтэд хүргэх	3,000,000	2018.04.05	2018.04.24	ЗХЗХ-ийн дарга Э.Эрдэнэхишиг	"Ийгл Бродкастинг" ХХК

Д / д	Гэрээний нэр	Гэрээний дугаар	Гэрээний үүрэг	Гэрээний үнийн дүн	Байгуулсан огноо	Дуусах хугацаа	Гэрээг байгуулсан албан тушаалтан	Гэрээний тал
6	Ажил гүйцэтгэх гэрээ	02/35	ТӨБЗГ-ын үйл ажиллагааны урсдаг титр мэдээг олон нийтэд хүргэх	1,160,000	2018.06.27	2018.12.24	ТӨБЗГ-ын ЗХЗХ-ийн дарга Б.Гаваа	"Эрдэнэт таймс" ХМБ
7	Ажил гүйцэтгэх гэрээ	03/40	ТӨБЗГ-ын үйл ажиллагааны талаар урсдаг титр мэдээг олон нийтэд хүргэх	3,000,000	2018.09.05	2018.09.25	ЗХЗХ-ийн дарга Б.Гаваа	"Ийгл Бродкастинг" ХХК

ИЛЭРСЭН АСУУДЛУУД

Хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан 7 гэрээнд 3 шалгуур үзүүлэлтийн дагуу аудит хийлээ. Нэгд, гэрээний үүрэг хариуцлага, үндэслэл, хэрэгжилт, хоёрт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа, гуравт, худалдан авах ажиллагааны талаар шалгуур тавьж, бодит нөхцөл байдлыг тусган харуулав.

Дотоод аудитын үнэлгээг тус бүрт нь “Хангалттай”, “Сайжруулалт хэрэгтэй”, “Их хэмжээний сайжруулалт хэрэгтэй”, “Хангалттай бус” гэсэн дөрвөн үнэлгээгээр үнэлж, нэгдсэн дүгнэлт болон зөвлөмжийг гаргалаа.

Шалгуур 1. Гэрээний үүрэг хариуцлага, үндэслэл, хэрэгжилт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний үүрэг, хариуцлага, эрх зүйн үндэслэл, хэрэгжилт болон гэрээний заалтыг баримталж ажилласан байх.

Бодит нөхцөл байдал

“Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал”-ыг нийтлэх, хамтран ажиллах гэрээг өдөр тутмын Өдрийн сонин, “Монгол Ньюс” ХХК (Өнөөдөр сонин), “Засгийн мэдээ” ХХК (Зууны мэдээ сонин), англи хэл дээр эрхлэн гаргадаг “Монгол Ньюс” ХХК (UB Post) сонинтой Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1-д зааснаар захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ гэж заасныг, Иргэний хуулийн 359 дүгээр зүйл хөлсөөр ажиллах гэж заасныг тус тус үндэслэн байгуулсан байна.

Ажил гүйцэтгэх гэрээг “Ийгл Бродкастинг” ХХК, “Эрдэнэт Таймс сонин” ХМБ-тай ТӨБЗГ-ын үйл ажиллагааны урсдаг титр мэдээг олон нийтэд хүргэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3-т зааснаар босго үнээс бага өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авч болно гэж заасныг, Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл ажил гүйцэтгэх гэрээ гэж заасныг тус тус үндэслэсэн байгаа нь гэрээг хууль, эрх зүйн үндэслэлтэй байгуулагдсан гэж үзэж байна.

Харин “Эрдэнэт таймс сонин” ХМБ-тай гэрээ байгуулахдаа Иргэний хуулийн 70 дугаар зүйлийн 1-д зааснаар төлөөлөгч нь төлөөлүүлэгчийнхээ нэрийн өмнөөс өөртэйгөө хэлцэл хийхийг хориглоно гэсэн заалтыг зөрчиж ажил гүйцэтгэгч (“Эрдэнэт таймс сонин” ХМБ)-ийг төлөөлж гэрээнд Б.Мөнгөнтуяа гарын үсэг зурж, өөрөө өөрийгөө баталж Б.Мөнгөнтуяа мөн гарын үсэг зурсан байна.

Гэрээний хэрэгжилтийн хувьд гэрээний зарим зүйл заалтыг хангаж ажиллаагүй байна. Үүнд:

“Эрдэнэт таймс сонин” ХМБ-тай байгуулсан гэрээний 2.3-т зааснаар гэрээний салшгүй хэсэг болох тусгай зөвшөөрөл хуулбарыг хавсаргаагүй байна.

Өдрийн сонинтой байгуулсан тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал"-ыг нийтлэх, хамтран ажиллах гэрээний 3.5-д захиалагч нь сонинд нийтлэгдсэн урилга, зарыг үндэслэж төлбөр тооцоог сар бүрийн 25-ны дотор барагдуулна, 5.2-т захиалагч нь сонинд хэвлүүлсний төлбөрийг дараа сар бүрийн 28-ны дотор нэхэмжлэлийн дагуу төлбөр хийнэ гэсэн хоёр заалт өөр байгаагаас үзвэл төлбөрийг төлөх хугацаа нь хоорондоо зөрүүтэй байна. Мөн тус гэрээний 1.2-т гэрээний салшгүй хэсэг болох гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл, гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гүйцэтгэгчийн ирүүлсэн тендер, үйл ажиллагааны хуваарь, төлбөрийн хуваарийг хавсаргах гэж заасны дагуу холбогдох баримт бичгийг хавсаргаагүй байна.

“Монгол Ньюс” ХХК, “Засгийн мэдээ” ХХК-тай байгуулсан гэрээний 1.2-т гэрээний салшгүй хэсэг болох гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл, гүйцэтгэгчийн ирүүлсэн тендер, үйл ажиллагааны хуваарь, төлбөрийн хуваарь зэрэг баримт бичгийг тус тус хавсаргаагүй байна.

“Ийгл Бродкастинг” ХХК-тай байгуулсан гэрээний 2.3-т гэрээний салшгүй хэсэг болох тусгай зөвшөөрөл, аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар, үнийн дүнгийн талаархи танилцуулга, мэдээлэл зэрэг баримт бичгийг хавсаргаагүй байна.

Үнэлгээ 1.

Гэрээг хангалттай үндэслэлтэй боловсруулсан боловч гэрээний зарим зүйл заалтыг хангаагүй тул **“Сайжруулалт хэрэгтэй”** гэсэн үнэлгээг өгч байна.

Шалгуур 2. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтаар баталгаажуулсан байх.

Бодит нөхцөл байдал

2018 оны 11 сарын 18-ны өдрөөр тасалбар болгон хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг анхан шатны баримтаар баталгаажуулсан эсэхийг шалгалаа. Гэрээний гүйцэтгэл болон анхан шатны баримтын бүрдлийн талаархи мэдээллийг 2 дугаар хүснэгтээр харуулбал:

2 дугаар хүснэгт

Д/д	Гүйцэтгэгчийн нэр	Дуусах хугацаа	Гэрээний үнийн дүн	Гүйцэтгэл	Анхан шатны баримтын бүрдэл	Дутуу баримтууд
1	Өдрийн сонин	2018.12.31	1/8 нэг бүрийн үнэ 70,000	9,408,000	Бүрэн	
2	"Монгол Ньюс" ХХК (Өнөөдөр сонин)	2018.12.31	1/8 нэг бүрийн үнэ 50,000	9,430,000	Дутуу	Төлбөрийн хүсэлтийн дугаар 178- сонин дутуу
3	"Монгол Ньюс" ХХК (UB Post сонин)	2018.12.31	1/8 нэг бүрийн үнэ 80,000	3,450,000	Дутуу	Төлбөрийн хүсэлтийн дугаар 80- 1 ш сонин дутуу, Төлбөрийн хүсэлтийн дугаар 232- 1 ш сонин дутуу, Төлбөрийн хүсэлтийн дугаар 329- 1 ш сонин дутуу
4	"Зууны мэдээ" сонин	2018.12.31	нэг бүрийн үнэ 50,000			
5	"Ийгл Бродкастинг" ХХК	2018.04.24	3,000,000	3,000,000	Бүрэн	
6	"Эрдэнэт таймс" ХМБ	2018.12.24	1,160,000	1,160,000	Бүрэн	
7	"Ийгл Бродкастинг" ХХК	2018.09.25	3.000.000	3.000.000	Бүрэн	

“Ийгл Бродкастинг” ХХК болон “Эрдэнэт таймс” ХМБ-тай байгуулсан гэрээний гүйцэтгэлийн анхан шатны баримтын бүрдэл хангалттай байна.

Гэвч “Монгол ньус” ХХК, “Засгийн мэдээ” ХХК-тай байгуулсан гэрээний анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7 анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно; 20 дугаар зүйлийн 1.1 нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах; 20 дугаар зүйлийн 1.4 хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулсан ажил, гүйлгээг бүртгэхгүй байх гэсэн заалтыг тус тус зөрчжээ.

Үнэлгээ 2.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг анхан шатны баримтаар баталгаажуулсан эсэхийг шалгахад зарим ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу тул **“Сайжруулалт хэрэгтэй”** гэсэн үнэлгээг өгч байна..

Шалгуур 3. Худалдан авах ажиллагаа

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хэвлэл, мэдээллийн байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажилласан байх.

Бодит нөхцөл байдал

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зүйл, заалтыг баримталж ажилласан эсэхийг 3 дугаар хүснэгтээр харуулбал:

3 дугаар хүснэгт

Д/д	Гэрээний нэр	Гэрээний дугаар	Гүйцэтгэгч тал	Худалдан авах ажиллагааны журам
1	"Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал"-ыг нийтлэх, хамтран ажиллах гэрээ	03/03	Өдрийн сонин	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг /цаашид “ТБОНӨБАҮХА” гэх/ хэрэгжүүлэхтэй холбогдуулан зөвлөхөөс бусад үйлчилгээний дотоодын болон олон улсын тендер шалгаруулалтад мөрдөх тендерийн жишиг баримт бичгийг Сангийн сайдын 2007 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн 176 тоот тушаалын дагуу тендер шалгаруулан ажилласан байна.
2	"Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал"-ыг нийтлэх, хамтран ажиллах гэрээ	03/04	"Монгол Ньюс" ХХК (Өнөөдөр сонин)	

Д/д	Гэрээний нэр	Гэрээний дугаар	Гүйцэтгэгч тал	Худалдан авах ажиллагааны журам
3	"Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал"-ыг нийтлэх, хамтран ажиллах гэрээ	03/06	"Зууны мэдээ" сонин	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг /цаашид "ТБОНӨБАҮХА" гэх/ хэрэгжүүлэхтэй холбогдуулан зөвлөхөөс бусад үйлчилгээний дотоодын болон олон улсын тендер шалгаруулалтад мөрдөх тендерийн жишиг баримт бичгийг Сангийн сайдын 2007 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн 176 тоот тушаалын дагуу тендер шалгаруулан ажилласан байна.
4	"Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарлал"-ыг нийтлэх, хамтран ажиллах гэрээ	03/05	"Монгол Ньюс" ХХК (UB Post сонин)	ТБОНӨБАҮХА тухай хуулийн 34.1.2-т заасны дагуу шууд гэрээ байгуулсан
5	Ажил гүйцэтгэх гэрээ	05/09	"Ийгл Бродкастинг" ХХК	ТБОНӨБАҮХА тухай хуулийн 7.3-т заасны дагуу шууд худалдан авалт хийсэн
6	Ажил гүйцэтгэх гэрээ	02/35	"Эрдэнэт таймс" ХМА	ТБОНӨБАҮХА тухай хуулийн 7.3-т заасны дагуу шууд худалдан авалт хийсэн
7	Ажил гүйцэтгэх гэрээ	03/40	"Ийгл Бродкастинг" ХХК	ТБОНӨБАҮХА тухай хуулийн 7.3-т заасны дагуу шууд худалдан авалт хийсэн

ТӨБЗГ-ын даргын А/173 дугаартай 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн тушаалын дагуу төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын урилга, зөвлөх үйлчилгээний зарыг олон нийтэд мэдээлэх өдөр тутмын сонинг шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороо байгуулан даргаар Б.Эрдэнэбулган, нарийн бичгийн даргаар С.Чинбат, гишүүдээр Э.Тамир, Т.Отгонтөгс, Р.Дуламжав нар ажиллажээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зөвлөхөөс бусад үйлчилгээний тендер зарласан. Нийт 5 оролцогчоос санал ирүүлснээс бүгд шаардлага хангаж, үнэлгээ хийхэд Өнөөдөр сонин 480 оноо, Зууны мэдээ сонин 438 оноо, Өдрийн сонин 400 оноо, Үндэсний шуудан сонин 370 оноо, Засгийн мэдээ сонин 355 оноо тус тус авсан байна. Тендерийн баримт бичигт заасны дагуу хамгийн өндөр оноо авсан сониноор Өнөөдөр, Зууны мэдээ, Өдрийн сонинг шалгаруулан гэрээ байгуулах эрх олгон, тендер хүчинтэй байх хугацаанд тус тус хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан байна. Тендерийн баримт бичгийн бүрдэл хангалттай сайн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1.2-т "оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол шууд гэрээ байгуулна" гэж заасны дагуу англи хэл дээр эрхлэн гаргадаг UB Post сонинтой шууд гэрээ байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3-т “босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авч болно” гэж заасны дагуу “Ийгл Бродкастинг” ХХК, “Эрдэнэт Таймс сонин” ХМБ-тай ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулсан байна.

Үнэлгээ 3.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хэвлэл, мэдээллийн байгууллагуудыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажилласан тул “хангалттай” гэж дүгнэж байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан нийт 7 гэрээнд 3 шалгуурын дагуу аудит хийж тус бүрт нь үнэлэхэд:

Нэгд, гэрээний үүрэг хариуцлага, үндэслэл, хэрэгжилтийн байдал **“Сайжруулалт хэрэгтэй”**,

Хоёрт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа **“Сайжруулалт хэрэгтэй”**,

Гуравт, худалдан авах ажиллагаа **“Хангалттай”**.

Тиймээс дээрхи үнэлгээнээс нэгдсэн дүгнэлтийг гаргахад хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилт, явц, баримтын бүрдэл зэргийг харгалзан үзэж **“Сайжруулалт хэрэгтэй”** гэсэн дүгнэлтийг гаргаж байна.

ЗӨВЛӨМЖ

2018 онд байгуулсан хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан гэрээнд аудит хийж доорхи зөвлөмж хүргүүлж байна.

1. Гэрээний төсөл боловсруулах явцад Иргэний хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа эсэхийг анхаарах, гэрээний зарим заалтууд хоорондоо зөрүүтэй байгаа эсэхийг хянах;
2. Гэрээнд заагдсан гэрээний салшгүй хэсэг болох баримт бичгийг бүрэн хавсаргах;
3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангах, гэрээ дүгнэсэн акт болон гүйцэтгэлийн тайлан, өдөр тутмын сонинд хэвлэгдсэн зарыг хавсаргаж байх;
4. Тендерийн шалгаруулалтад ирүүлсэн баримт бичиг, түүнтэй холбоотой материалыг тухай бүр тендер шалгаруулалтын архивын нэгж болгон хадгалж байх;

5. Гэрээний бүртгэл хариуцсан хуулийн мэргэжилтэн гэрээний товъёог гаргаж, гэрээний бүрдлийг хангасан эсэхийг шалган, хүлээж авч байх.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Тайлан боловсруулсан:

Дотоод аудитын мэргэжилтэн



2019.1.2

Г.Оюунтөгөлдөр


Хянасан:

Дарга



Б.Ганбат

Захиргаа, хууль зүйн хэлтсийн
хуулийн ахлах мэргэжилтэн



2019.01.09

Э.Эрдэнэжишиг

Танилцсан:

Захиргаа, хууль зүйн хэлтсийн
хэвлэл мэдээлэл, олон нийт
хариуцсан мэргэжилтэн



Б.Дэлгэрцэцэг

Захиргаа, хууль зүйн хэлтсийн
хуулийн мэргэжилтэн




Б.Амарзаяа

Захиргаа, хууль зүйн хэлтсийн
ахлах нягтлан бодогч



Ж.Мөнхтүвшин

Худалдан авах ажиллагааны
хэлтсийн мэргэжилтэн



2019.01.02

С.Чинбат

oOo